

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ 2022 ОНД
БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙЖ ӨГСӨН НИЙТЛЭГ АНХААРАХ ЗӨВЛӨМЖ

ТЗУХ

-Тайланг хуваарийн дагуу хугацаандаа ирүүлэх

-Ил тод байдлын 46 шалгуур үзүүлэлтийн дагуу (аймгийн сайтад байршуулсан цэс-д мэдээгээ тогтмол оруулж хэвших)

-Гадаад хамтын ажиллагаанд дээд шатны байгууллагаас зөвлөмж авах, ашгийн бус төсөл бичих, сургалтын хүрээнд төсөл бичсэн байх

/ХЭЗХ/

-Эрх зүйн хөтөч нарын дунд зарласан болзолт уралдааныг эрчимжүүлж, зохион байгуулах 11 үйл ажиллагаа бүрд сумын ЗДТГ-ын дарга хяналт тавьж ажиллах.

-Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажилд “Эрх зүйн хөтөч” нарыг багаар ажиллуулан тэдэнд дэмжлэг үзүүлж, эрх зүйн сургалт сурталчилгааг 16-аас дээш насны иргэдийн 15 хүртэлх хувьд хүргэх.

-Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг сумын Засаг даргын зөвлөл, зурлаар хэлэлцүүлэн батлуулж, тайланг сумын ИТХ-ын дэргэдэх зөвлөлөөр зэлэлцүүлэн үнэлүүлж, үнэлсэн шийдвэрийн хамт тайланг 12 дугаар сарын 05-ны дотор ХЭЗХ-т ирүүлэх.

-Эрх бүхий албан тушаалтнуудын дунд зарласан уралдааныг эрчимжүүлж, зохион байгуулах 13 арга хэмжээ нэг бүрийг иргэд, олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж, сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулах.

-Нийтийн албанд нэр дэвшиж буй ТЗ-06-аас дээших албан тушаалтнууд болон төрийн байгууллагуудын удирдлага, ерөнхий нягтлан бодогч нарыг ХАСУМ-ийг хянуулсны дараа томилгоо хийж, ХАСХОМ-ийг 30 хоногт багтаан авах.

-Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй үед мэдэгдэл, тайлбарыг тухай бүрд авч хэвшүүлэх.

НБХ

1. Гэрээнд тусгагдсан бүлэг, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн тайлагнах /Дэрэн-соёл урлагийн, Хулд-эрүүл мэнд, соёл урлагийн, Сайхан – Овоо боловсролын хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй/
2. Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг бичихдээ тухайн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хувь, тоотой харьцуулж үзэх хувь, тоог баримтыг бичих
3. Соёлын төвийн мэргэжлийн бус ажилтнуудыг соёл урлагийн мэргэжил эзэмших сургалтад хамруулж, хүний нөөцийн чадавхыг сайжруулах
4. Соёлын өвийг хадгалан хамгаалах, өвлүүлэн хөгжүүлэх чиглэлийн ажлыг нэмэгдүүлэх
5. Өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг эрчимжүүлэх, дүн мэдээг бодитой болгох

6. Нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэрийн брэнд бий болгоход дэмжлэг үзүүлэх
7. Биеийн тамир, спортын орон тооны болон орон тооны бус арга зүйчийг авч ажиллуулах
8. Иргэдийг алхах, гүйх, дугуй унах, иог, хийн дасгал, аэробик, фитнес, спиннинг, бүжиг зэрэг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх
9. Спортын анхан шатны тэмцээн, уралдааныг сумандaa зохион байгуулж, түүнээс шалгарсан тамирчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд тогтмол оролцуулах
- 10.Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд сумын хүн амынхаа 25-аас доошгүй хувийг хамруулах
- 11.Боловсролын байгууллагуудын хөгжим, биеийн тамир, мэдээлэл зүйн кабинетыг өргөжүүлэх, шинээр бий болгох
- 12.Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр 70 доош үнэлэгдсэн сумд онцгойлон анхаарч хяналтдаа авч, хэрэгжилтийг хангах

Дэд бүтэц хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, өмчийн бодлого зохицуулалтын хүрээнд:

- 1.1. ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг олон нийтэд мэдээлэх
- 1.2. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын дагуу санхүүжилт гаргах, баримтын бүрдлийг хангах
- 1.3. ОНХС-ын удирдлагын системд мэдээллийг тухай бүр оруулах
- 1.4. Эрдэнэдалай, Дэрэн, Өндөршил, Дэлгэрхангай сумд "Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах ажлыг эрчимжүүлж хүлээн авах ажлыг зохион байгуулах
- 1.5. Техникийн хяналтын үзлэгт сумынхаа албан байгууллага, иргэдийн болон нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах
- 1.6. Улсын болон орон нутгийн хөгжлийн сан, гадаадын төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа ажлыг графикийн дагуу эрчимжүүлэх
- 1.7. Адаацаг, Говь-Угтаал, Сайхан-Овоо, Цагаандэлгэр сумд "Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах ажлын хөрөнгийг шийдвэрлүүлэх.
- 1.8. Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Эрдэнэдалай сумд ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоож Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаараа батлуулах, дэглэмийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулах
- 1.9. 2022 оны сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаснаас бусад газарт газар эзэмшүүлэхгүй байх.
- 1.10.Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Өлзийт сумд "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 3.2.5 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Иргэний нисэхийн ерөнхий газартай

хамтран шаардлагатай сумуудад Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасыг сонгон Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтын дагуу орон нутгийн тусгай хэрэгцээний газарт авах ажлыг зохион байгуулах

2. Хүнс, хөдөө аж ахуй үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр:

- 2.1. Сумын цөм сүргийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулж, захиалсан ээмэгний төлбөрийг "Малын генетик нөөцийн тухай хууль"-ийн дагуу малчдаас хуримтлуулж 100 хувь барагдуулах
- 2.2. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг бүрэн хангуулах сумын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах
- 2.3. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилтийн төслөөс хийгдэх ажлыг гүйцэтгэхэд явцын хяналтыг сайжруулж чанартай хийлгэхэд анхаарах
- 2.4. Мал ангилах заавар журмын дагуу хавар, намрын үржлийн мал ангилах, ашиг шимиийг тооцох
- 2.5. Хээлтүүлэгч мал ялган суурилах ажлыг сум орон нутагтаа чанартай зохион байгуулах
- 2.6. Сум орон нутгийн хэмжээнд жишсэн дундаж хүн амын суурь судалгаа тооцооллыг гаргаж, хүн амын стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах
- 2.7. Үндэсний хөтөлбөрүүдийн төлөвлөгөө боловсруулан батлуулж хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тооцож ажиллах
- 2.8. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарт шинээр батлагдсан эрх зүйн баримт бичгийг сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах
- 2.9. Мал, амьтны өвчлөлийн дуудлага бүрд малын эмч нарыг хүрч ажиллуулан тэдгээрээс эмгэгт материалын сорьц авхуулж аймгийн Мал эмнэлгийн лабораторид тухай бүр хүргүүлж шинжлүүлэн дүн, дүгнэлтийг гаргуулан тэмцэх, сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх
- 2.10. Мал эмнэлгийн цахим системийн хэрэгжилтийг хангуулж, малын эмчийг стандартын дагуу тогтвортой суурьшилтай ажиллахад шаардлага тавьж ажиллах
- 2.11. Тухайн сумын мал, амьтанд илэрдэг халдварт, халдваргүй, шимэгчтэх өвчний дуудлага бүрд Мал эмнэлгийн тасаг (МЭТ), Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (МЭҮН) хүрч ажиллах, хагас жил, жилийн эцсээр тайлагнах
- 2.12. Мал, амьтны өвчлөл бүртгэгдсэн тохиолдол бүрийг сумын газрын зурагт тэмдэглэх (халдварт, шимэгчлэх өвчний зураглал хийсэн байна)
- 2.13. Тухайн суманд хэрэгжүүлэх мал, амьтны дархлаажуулалтын ажлыг графикт хугацаанд захирамж, зарлан мэдээлэх товыг гаргаж хэрэгжүүлэх
- 2.14. Тухайн суманд хэрэгжүүлэх мал, амьтны өвчний халдвар илрүүлэх тандалтын ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулахад анхаарах, хэрэгжилтийг хангуулж ажиллах

- 2.15. Бруцеллөз өвчний байгалийн халдварт илрүүлэх тандалтад сумын нийт бух, буур, хуц, ухныг ялган суурилж, ээмэгжүүлэн шинжилгээнд 100% хамруулах
- 2.16. Малын эрүүл мэндийн үзлэг, угаалга, боловсруулалт, сэг зэм устгал, хороо хашааны халдвартгүйтгэлийг сумын хэмжээнд оновчтой зохион байгуулах
3. **Байгаль орчин аялал жуулчлал уул уурхайн чиглэлээр:**
- 3.1. "Нөхөн сэргээлт-2024" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлагнах, байгаль орчны хяналт хариуцлагыг сайжруулах.
 - 3.2. Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэмдэгжүүлэлтийн ажил зохион байгуулах.
(Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан сум)
 - 3.3. "Ногоон паспорт-Ногоон төгөл" цэцэрлэгийг орон нутгийн өмчид бүртгэн авах, цаашид өргөжүүлж мод тарих. (Гурвансайхан сум)
 - 3.4. Сумандaa 5-аас доошгүй ангилан ялгах хогийн сав байршуулж, хуванцар хаягдлыг аймагт нийлүүлж хог хаягдал ангилан ялгах ажлыг эхлүүлэх.
 - 3.5. Аймаг, орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газар нутгийн холбогдох шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах.
 - 3.6. Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, эрхзүйн хувьд чадамжгүй тогтоолыг шинэчилж, цэгийн давхцлыг арилгах ажил зохион байгуулах.
 - 3.7. Зэрлэг амьтдад жилийн эцэст буюу 12 дугаар сард биотехникийн арга хэмжээ авч ажиллах./Сайхан-Овоо, Баянжаргалан, Өндөршил, Өлзийт, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Адаацаг сум /
 - 3.8. Аялал жуулчлалын гол бүс нутаг, байгалийн үзэсгэлэнт газруудад гадаад, дотоодын жуулчдыг ая тухтай аялах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тохижилтын ажлыг хамтран хэрэгжүүлэх. /Өлзийт, Адаацаг, Дэлгэрхангай болон холбогдох сум/
 - 3.9. Жуулчдыг татах уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэх "Морьтой Монгол аялал", "Малчны баяр" эвент арга хэмжээг зохион байгуулах. /Говь-Угтаал, Сайхан-Овоо болон холбогдох сум/
 - 3.10. Гэрээний шалгуур үзүүлэлт болон хүрэх дүн уялдахгүй байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР